



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2015 оны 12 сарын 30 өдөр

Дугаар 93

Мандалговь

Хөрөнгө бүртгэх тухай

Монгол Улсын "Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль"-ийн 77 дугаар зүйлийн 77.2.3, 77.3 заалт, Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны 232 тоот тогтоолоор батлагдсан "Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1 дэх заалтыг үндэслэн Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

1. Аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газарт өөрийн давсан орлогоос 1,300,000 /нэг сая гурван зуун мянга/ төгрөгөөр байгууллагын албан хэрэгцээнд ашиглах NIKON D90 маркийн зургийн аппарат бэлтгэж, үндсэн хөрөнгийг данс бүртгэлдээ бүртгэн авахыг зөвшөөрсүгэй.

2. Шинээр бэлтгэсэн эд хөрөнгийг холбогдох хууль тогтоомжийн дагуу байгууллагын данс бүртгэлд бүртгэж авахыг Хүнс, Хөдөө аж ахуйн газрын дарга Г.Дашбалданд даалгасугай.

3. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Орон нутгийн өмчийн албаны дарга П.Очирбатад үүрэг болгосугай.

ДАРГА  С.БУДЖАВ



0100204